

**2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ЗАСАГ ДАРГААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 06 дугаар сарын 19-ний “Даваа” гарагийн 12:00 цагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т word файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

**Үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлтийг хугацаа хэтрүүлж ирүүлэхгүй байхад анхаарна уу, хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд хүлээн авч, нэгтгэлд оруулахгүй болно.**

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
<b>БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>		
1	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, байгууллагууд эхний хагас жилийн гүйцэтгэлийг хугацаанд нь тайлагнаж ажиллах.	ТЗУХ, ААНБ-ууд
2	Нийслэлийн хэмжээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг бүх шатандаа эрчимжүүлж ажиллах. Үүнд:  1. Авто замын салбарт /явган зам, дугуйн зам/ 2. Барилга, байгууламж, дэд бүтцийн салбарт 3. Тохижилт, ногоон байгууламж, гэрэлтүүлэг гэх мэт	СТСХ, ТХҮХ
<b>ИРГЭДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>		
3	Орчны тоосжилт, агаарыг чийгшүүлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ногоон байгууламжийг тогтмол услах, цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, усан оргилууруудыг бүрэн ажилд оруулж, тохижилт, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажлаа эрчимжүүлэх	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
4	Нийслэлийн хэмжээнд хөрөнгө оруулалт бүтээн, байгуулалт, тохижилтын ажлын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэх, эзэмшилт, ашиглалтыг тодорхой болгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	СТСХ
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
5	2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 14:00 цагаас зохион байгуулагдах дүүргийн 1 дүгээр хорооны “Сууц өмчлөгчдийн холбоо”-ны хурлын ирцийг бүрдүүлэхэд анхаарч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, 2 дугаар хорооны СӨХ-ны хурлын товыг тогтоох.	ААНБ-ууд, Хороод
6	Улс, нийслэлийн төсвийн тодотгол батлагдаж байгаатай холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагууд харьяалах дээд шатны байгууллагадаа тайлан мэдээгээ хүргүүлж, төсөв санхүү шийдвэрлүүлэх талаар анхаарч ажиллах.	ААНБ-ууд
7	2023 оны ЕБС-ийн төгсөгчдийн ЭЕШ-ын үеэр сурагчдын тээвэрлэлт, аюулгүй байдалд анхаарч, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах.	Боловсролын хэлтэс, ХЦС
8	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, авто замын бордюрын эвдрэл гэмтлийг засварлах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
9	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн асалтыг 100 хувьд хүргэж ажиллах.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
10	2023 оны эхний хагас жилийн тайлан биелэлтийг ирүүлэхдээ чанар гүйцэтгэл, хугацаанд анхаарч, хянаж баталгаажуулан ирүүлэх.	ААНБ-ууд